

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХИЙН БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UHMN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ
2006 ОН

ТАЛАРХАЛ

Өнөөгийн нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах үүднээс зохион байгуулж буй энэ удаагийн судалгаанд оролцсон нийт хүмүүст гүн талархал илэрхийлье. Тэр дундаа судалгаанд идэвхтэй оролцон, цаг зав зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгч болон бусад хүмүүст гүн талархал дэвшүүлж байна.

Энэхүү судалгааг явуулахад санхүү болон техникийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн НҮБ-ын Хүүхдийн Сан болон МУ-ын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоонд талархал илэрхийлье.

“Social Monitoring” Хөгжлийн Судалгааны Төв



ГАРЧИГ

Талархал	3
Товчилсон үгийн тайлбар	5
Хүснэгтийн жагсаалт	6
Судалгааны үндэслэл	7
Судалгааны арга зүй	8
Сурч боловсрох эрхийн байдал	9
Судалгааны санал зөвлөмж	13
Эрүүл байх, эмнэлгийн тусламж үйлчилгээ хүртэх эрхийн байдал	14
Судалгааны санал зөвлөмж	20
Нийгмийн халамж үйлчилгээ хүртэх эрхийн байдал	20
Судалгааны санал зөвлөмж	25
Нийгмийн оролцоо	25
Судалгааны санал зөвлөмж	28
Хавсралт	
Асуумж хуудас	
Тайлан бичихэд оролцогсад	

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ТОВЧИЛСОН ҮГ

АХБ	Азийн хөгжлийн банк
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НСТ	Нөхөн сэргээх Төв
ОУБ	Олон Улсын байгууллага
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБИНХХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм хамгааллын хууль
ХЭК	Хүүхдийн эрхийн конвенци
ХЭХ	Хүүхдийн эрхийн хороо
ҮСГ	Үндэсний статистикийн газар
СД	Стандарт дүрэм
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮСНЭГТИЙН АГУУЛГА

- Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн хүйс
- Хүснэгт 2. Боловсролд хамрагдсан эсэх
- Хүснэгт 3. Зааж буй хичээлийг бүрэн ойлгодог эсэх
- Хүснэгт 4. Сургуульд сурахад тулгарч буй бэрхшээл
- Хүснэгт 5. Боловсролд хамрагдаж чадахгүй байгаагийн шалтгаан
- Хүснэгт 6. Сургуульд сурахыг хүсдэг эсэх
- Хүснэгт 7. Хүүхдээ сургуульд явуулах талаар гаргасан эцэг эхийн санаачлага
- Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй эсэх.
- Хүснэгт 9. Эмнэлэгт үзүүлэхэд бэрхшээлтэй эсэх.
- Хүснэгт 10. Эмнэлэгт үзүүлэхэд зонхилон тохиолддог хүндрэлүүд.
- Хүснэгт 11. Нийгмийн халамж үйлчилгээ авдаг эсэх
- Хүснэгт 12. Ямар төрлийн нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт авдаг вэ?
- Хүснэгт 13. Танд хэн илүү тусалдаг вэ?
- Хүснэгт 14. Таны асран хамгаалагч ажил эрхэлдэг эсэх.
- Хүснэгт 15. Нийгэм, соёлын арга хэмжээнд оролцдог эсэх
- Хүснэгт 16. Үзвэр үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагийн шалтгаан
- Хүснэгт 17. Хөгжлийн бэрхшээлтэй чинь холбоотойгоор хэн нэгэн таныг гомдоосон эсэх
- Хүснэгт 18. ХБХ-дэд дараах зүйл тохиолддог эсэх
- Хүснэгт 19. ХБХ-ийг гэрийнхэн нь ойлгодог эсэх
- Хүснэгт 20. Сэтгэл санааны хувьд ганцаарддаг эсэх
- Хүснэгт 21. Хүүхэд өөртөө итгэлтэй эсэх
- Хүснэгт 22. ХБХ гэртээ хангалуун байдаг эсэх
- Хүснэгт 23. Амьд явах эрхийн мэдлэг
- Хүснэгт 24. Хамгаалуулах эрхийн мэдлэг
- Хүснэгт 25. Эрүүл мэндийн үйлчилгээ авах
- Хүснэгт 26. Боловсрол эзэмших эрх
- Хүснэгт 27. Ялгаварлан гадуурхагдахгүй байх
- Хүснэгт 28. Хүчирхийллээс ангид байх
- Хүснэгт 29. Нийгмийн амьдралд тэгш оролцох

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Судалгааны үндэслэл

Монгол Улсад мөрдөгдөж буй хуульд, тодруулбал 2005 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийн 3.1-г зааснаар “Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж ойлгоно” хэмээн тодорхойлжээ.¹

Энэхүү хуулийн заалттай холбоотой мөрдөгдөж буй тодорхой шалгуур одоогийн байдлаар улсын хэмжээнд байхгүй байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар хийгдсэн нэгдсэн судалгаа өнөөг хүртэл алга байна. Урьд өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар хийгдэж байсан судалгаа нь статистик тоо баримтын хувьд нэг нь нөгөөгөөсөө хол зөрөөтэй байна. Тухайлбал, Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалалын яамнаас (тухайн үеийн нэрээр) 1998 онд гаргасан мэдээгээр нийт хүн амын 4,8 хувь буюу 115 мянган хүн хөгжлийн бэрхшээлтэй² гэж мэдээлсэн байхад, тухайн онд ҮСГ-аас гаргасан

мэдээнд нийт 29 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн³ байна гэж тодорхойлж байжээ.

2004 онд Үндэсний статистикийн газраас Азийн Хөгжлийн Банкны техникийн тусламжаар хийгдсэн түүвэр судалгаанд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 12,7 хувийг 0-19 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эзэлж буйг дурджээ. Дээрх байдлаас үзэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар хийгдсэн нэгдсэн судалгаа шинжилгээний дорвитой ажил хийгдээгүй, мөн “хөгжлийн бэрхшээл” гэж юуг үзэх талаар тодорхой шалгуур байхгүй байгаагийн зэрэгцээ хамгийн гол сэтгэл түгшээсэн зүйл нь төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар баримталж буй нэгдсэн бодлогогүй байгаад асуудлын гол оршиж байна.

Энэ удаагийн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо хувь хэмжээ, бэрхшээлийн хэлбэрийг тодруулахыг урьдал болгоогүй ба уг судалгаа нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан хүүхдийн сурч боловсрох, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ авах эрхүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хэрхэн хэрэгжиж буйг тодруулах зорилготой болно.

¹ХБИ-ний нийгмийн хамгааллын тухай хууль

²ЭМЯ, НХЯ-ны статистик 1998

³ҮСГ 1998

Судалгааны зорилго

Монгол Улсад НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенци түүний хэрэгжилт ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үндсэн эрхийн хэрэгжилт ямар төвшинд явагдаж буйг харуулах нөгөө талаар ХБХ-ийн эрх зүйн актууд, холбогдох хууль тогтоомж, бодлого, түүний хэрэгжилтийг харьцуулах, дүн шинжилгээ хийх зорилгоор уг судалгаа хийгдэв.

Судалгааны хүрээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хэрэгжилтийг тодорхойлох зорилготойгоор уг судалгаа хийгдэж буй тул дараах субъектууд хамрагдлаа.

Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
- ХБХ-ийн эцэг, эхчүүд
- ХБХ-тэй ажилладаг мэргэжлийн байгууллага
- Холбогдох бусад байгууллагууд

Судалгааны аргачлал

Уг судалгаагаар судалгаанд хамрагдсан орон нутаг түүнчлэн тухайн нутаг дэвсгэрт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх тоон ба чанарын мэдээлэл цуглуулж судалгааны эцсийн тайлан мөн санал зөвлөмжийг гаргав.

Судалгаанд дор дурдсан аргуудыг ашиглав.

Ярилцлага - Тоон ба чанарын асуултууд орох ба чөлөөт (open-ended), тодорхой хариулт (closed)-аар авна.

Хувьчилсан ярилцлага - тодорхой заасан сэдвээр эсвэл тодорхой хувь хүнтэй ярилцах

Асуулга - хэмжих үзүүлэлттэй холбоотойгоор асуулга авна

Бүлгийн ярилцлага - 12-15 хүнийг багтаасан ярилцлага

Кейс жишээ - Тодорхой болсон үйл явдлын дүн шинжилгээ

Харьцуулалт дүн шинжилгээ

2-догч мэдээлэлтэй харьцуулалт хийх.

Сонирхогч талууд

Судалгааны явц, түүний эцсийн тайлан, үр дүн сонирхогч талуудад бүрэн нээлттэй байна.

Мэдээлэл цуглуулалт

Уг судалгаа нь цаг хугацааны хувьд давчуу байсан тул судалгаанд шаардлагатай үндсэн мэдээллийг цуглуулахын тул судалгааны 3-н багийг зохион байгуулж ажиллуулсан.

ХБХ-ийн эрх зүйн актууд, хууль тогтоомжуудыг холбогдох байгууллагуудаас тухайлбал БСШУЯам,

Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, орон нутгын эрүүл мэндийн газар, боловсролын газар, нийгмийн халамж үйлчилгээний газраас тус тус цуглуулж бодлого, түүний хэрэгжилтийг харьцуулан дүн шинжилгээ хийсэн.

Түүнчлэн судалгааны гол субъектууд болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтан нар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг эмч эмнэлгийн ажилтан, асуудал хариуцсан төрийн албан хаагчид мөн зарим ТББ-ын холбогдох хүмүүстэй бүлгийн болон хувьчилсан ярилцлага, анкетын санал асуулга зохион байгуулан тэдгээрт дүн шинжилгээ хийн уг судалгааны тайланд тусгасан болно.

Мэдээллийн боловсруулалт

Судалгааны баг SPSS10.0 программыг судалгааны мэдээлэл боловсруулахад ашигласан.


Судалгааны үр дүн

Судалгаанд Улаанбаатар хотын 5 тусгай сургууль, Дорнод аймгийн 1 ЕБС-ийн тусгай сургалттай анги, хөгжлийн бэрхшээлтэй нийт 102 хүүхдүүд оролцсон.

Судалгаанд өөрөө бие даан хариулах чадвартай 10-17 насны хүүхдүүдийг

хамруулан оролцуулсан. (Анкетын асуумжийг тайланд хавсаргав).

Хүснэгт 1. Нийт хүүхдүүдийн хүйс



Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 30 эцэг эхчүүд, 18 багш сурган хүмүүжүүлэгч, төрийн болон төрийн бус байгууллагын 20, холбогдох төлөөлөгчидтэй хувьчилсан ба бүлгийн ярилцлага хийсэн.

Нэг. Сурч боловсрох эрх

Судалгаанд нийт 102 хүүхдүүд оролцсоноос тусгай сургалттай сургуулиудаас 83, ЕБС-ын тусгай сургалттай ангиас 12, сургуульд сурдаггүй 7 хүүхэд хамрагдлаа.


Хүснэгт 2. Боловсролд хамрагдсан байдал



Тусгай сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ЕБС-аас тусгай сургуульд шилжихэд ердийн сургуульд сурч байснаасаа сурлагын идэвх

сайжирдаг. Сургуулийн өмнөх ба бага боловсрол эзэмших үедээ тэдний сурлага сурах идэвхи харьцангуй сайн байдаг боловч өсвөр насандаа бусдаас ичэх хандлагатай, сурах идэвхи сулардаг байна.

Хүснэгт 3. Багшийн зааж буй хичээлийг бүрэн ойлгодог эсэх




Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 75% нь хичээлээ бүрэн ойлгодог, 25% нь хичээлээ бүрэн ойлгодоггүй гэсэн байна. Тусгай сургалттай сургуульд сурч буй хүүхдүүдийн сурлагын хоцорогдлын гол шалтгаан нь хөнгөн ба дунд хэлбрийн оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эрт оношлогдохгүй ЕБС-д тодорхой хэмжээний цаг хугацаа алддагтай холбоотой. Үүнийг тухайн хүүхдийн эцэг эхийн мөн ЕБС-ын багш нарын хандлага, идэвхи санаачилгатай холбож болно. ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээл заах тусгай хөтөлбөр түүнчлэн тэдний сурлагыг дүгнэх тусгай аргачлалгүй, эдгээр хүүхдүүдтэй ажиллахад багш нарт ямар нэг урамшуулал байдаггүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурлагаар хэт хоцрогдон, багш хамт олны дунд

ялгаварлан гадуурхагдан эцэстээ тусгай сургуульд шилждэг байна. Ингэж шилжиж ирэхдээ тухайн хүүхэд нь тусгай сургуульд сурч буй үеийнхээ хүүхдүүдийн сурлагын төвшингөөс ч хоцорогдсон байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагдахад сөргөөр нөлөөлж байгаа үндсэн бэрхшээлүүдийг судалгаанд хамрагдсан хүүхдүүд доорх байдлаар хариулжээ.

Хүснэгт 4. Сургуульд сурахад тулгарч буй бэрхшээл



Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 31% нь сургууль нь гэрээс хол байгааг дурджээ энэ нь тойргын хамрагдах хүрээ өргөн учраас холоос хүүхдүүд сургуульдаа явдаг байна. Мөн нийт хүүхдүүдийн 40% нь сургуульд ирж, очиход унааны зардал хүндрэлтэй байгааг хэлсэн ба энэ нь эдгээр хүүхдүүдийн ар гэрийн амьдрал амьжиргааны дундаж төвшингээс доогуур төвшинд амьдарч байгаатай холбоотой байна. Нийт хүүхдүүдийн 9% нь тэдний ар гэрийнхэн нь хүндрэл учруулдагыг дурджээ. Нийт хүүхдүүдийн

20% нь хичээлээ бүрэн ойлгодоггүй гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдах боломжгүй байгаа үндсэн шалтгааныг доорхи хүснэгтэнд харуулав.


Хүснэгт 5. Боловсролд хамрагдаж чадахгүй байгаагийн шалтгаан



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 47% нь тэдний хөгжлийн бэрхшээлээс шалтгаалж боловсролд хамрагдах боломжгүй байгаа гэжээ. Ихэвчлэн эдгээр хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээл нь тэднийг суралцах, сургуульд явахад нь тохиолдоод байгаа хүндрэл бөгөөд гол төлөв хүнд хэлбрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байдаг. Мөн судалгаанд оролцсон хүүхдүүдийн 38% нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон сургууль байхгүй буюу сургууль хүлээж авдаггүй гэж хариулжээ. Эдгээр хүүхдүүд нь гол төлөв тархины саажилттай хүүхдүүд байдаг. Түүнчлэн судалгаанд оролцсон хүүхдүүдийн 15% нь сургууль тухайн хүүхдийн гэрээс хол байдаг гэж хариулжээ. Тархины саажилттай болон тулгуур эрхтний

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах сонирхолыг дараах хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 6. Сургуульд сурахыг хүсдэг эсэх



Судалгаанд оролцсон боловсролд хамрагдаагүй хүүхдүүдийн 71% нь сургуульд сурахыг хүсдэг, 29% нь мэдэхгүй гэж хариулжээ. Саажилттай болон тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь ихэвчлэн оюун ухааны хувьд эрүүл байдаг боловч эдгээр хүүхдүүдэд зориулсан нийгмийн дэд бүтэц хөгжөөгүй, тэдэнд зориулсан сургууль, цэцэрлэг байхгүй мөн багш сурган хүмүүжүүлэгч бэлтгэгдээгүй зэрэг шалтгааны улмаас эдгээр хүүхдүүд боловсролд хамрагдаж чаддаггүй байна.

Боловсролд хамрагдаагүй хүүхдүүдийн эцэг эхийн идэвхи санаачилгын талаар хүүхдүүдийн саналыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7. Хүүхдээ сургуульд явуулах талаар гаргасан эцэг эхийн санаачлага



Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 29% нь тэдний эцэг эх тухайн хүүхдийг боловсролд хамруулах талаар ямар нэг байдлаар санаачилга гаргасан гэж үзсэн байхад, дийлэнх нь буюу 57% нь тэдний эцэг эх тухайн хүүхдийг боловсролд хамруулах талаар санаачилга гаргасан эсэхийг мэдэхгүй гэж хариулжээ. Эцэг эх нь тухайн хүүхдийг боловсролд хамруулах талаар санаачилга гаргаагүй гэж 14% нь хариулжээ.

Хувьчилсан болон бүлгийн ярилцлага

Судалгааны явцад “Сурч боловсрох эрх”-ийн талаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг боловсролын байгууллагын нийт 23 багш сурган хүмүүжүүлэгчид, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 11 эцэг эхчүүдтэй бүлгийн болон хувьчилсан ярилцлагыг зохион байгуулав.

Ярилцлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаархи урьдчилан төлөвлөсөн асуултаар асууж ярилцсан болно.

Уг ярилцлагаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсроход тулгарч буй бэрхшээл, хийгдэж буй ажлууд,

боловсролын байгууллагын үйл ажиллагааны тогтолцоо ялангуяа ерөнхий боловсролын сургуулиудад сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурлагыг хэрхэн үнэлэх, цаашид эдгээр хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хэрхэн хангах талаар ярилцав.

Ярилцлагын үед дараах үндсэн асуудлууд илэрсэн. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуульд оюуны хөнгөн хэлбрийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хөтөлбөр байдаггүй иймээс эдгээр хүүхдүүдийн дунд сурлагын хоцрогдол их гардаг бөгөөд хэрэв хөгжлийн бэрхшээлтэй эдгээр хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөрөөр хичээлийг явуулбал тэдний сурах идэвх сайжран эрүүл хүүхдүүдийн дунд сурч боловсрох бүрэн боломжтой гэж үзлээ.

- Эрүүл хүүхдийн сурлагын үнэлгээний аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагыг үнэлдэгээс шалтгаалж ерөнхий боловсролын сургуулиудад сурлагын хоцрогдол гарах нэг шалтгаан болдгыг дурджээ.

Нийгэм олон нийтийн зүгээс тэдэнд хандах хандлага харьцангуй сайжирсан. Төр засгийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар барьж буй цэгцтэй бодлого байдаггүй, ОУ-ын байгууллага бусад буяны байгууллагууд, мөн зарим

төсөл хөтөлбөрийн хүрээнд эдгээр хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явагдаж байгааг судалгаанд оролцогчид дурджээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоог хангах зорилгоор тэдэнд зориулсан нийгмийн дэд бүтэц тухайлбал, налуу шат, нийтийн бие засах газарт тэдэнд зориулсан тусгай суултуур, зам талбайн тусгай тэмдэглэл улсын хэмжээнд үндсэндээ хийгдээгүй байгааг онцолсон байна.

Тусгай сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сурах бичиг байхгүй түүнчлэн эдгээр сургуулиудад багшлах мэргэжлийн боловсон хүчнийг улсын хэмжээнд бэлтгэхгүй байгаа талаар судалгаанд оролцсон багш сурган хүмүүжүүлэгчид дурдсан байна.

Судалгааны явцад ажиглагдсан нэг зүйл нь улсын хэмжээнд хичнээн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагдаж чадаагүй байгааг үзүүлэх тоо баримт алга байна. Боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гол шалтгааныг судалгаанд оролцогчид дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

- Хүнд хэлбрийн бэрхшээлтэй хүүхдүүд
- Ахуйн хоцрогдолтой хүүдүүд

- Амьдралын боломжгүй байдал
- Зарим эцэг эхийн идэвх санаачлага муу
- Нийгмийн таатай нөхцөл бүрдээгүй

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхтэй холбоотой санал зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн байдлыг тодорхойлох судалгааны энэ хэсэгт тусгай сургалттай 5 сургууль, ерөнхий боловсролын 3 сургууль, 2 нөхөн сэргээх төвийн нийт 23 багш сурган хүмүүжүүлэгчид, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 11 эцэг эхчүүд, 102 боловсролд хамрагдаж буй болон хамрагдаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийт 136 оролцогчид хамрагдав. Ийнхүү судалгаанд оролцогчидоос авсан хариулт, хувьчилсан болоод бүлгийн ярилцлагын дүгнэлтийг үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

- Хүний хөгжлийн болон эмнэл зүйн аргачлалаар “хөгжлийн бэрхшээл”-ийг тодорхойлж, нэгдсэн нэг ойлголтонд хүрэх
- Дээрх үйл ажиллагаан дээр үндэслэн улсын хэмжээнд нэгдсэн аргачлалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар судалгаа явуулж улсын хэмжээний нэгдсэн мэдээллийн сантай болох

- Үүнтэй уялдуулж, нийгэм эдийн засгийн үндэслэлийг тооцон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулах
- Нийгэм олон нийтийн хандлагыг өөрчлөх
- Эцэг эх, сургуулийн зүгээс тэдэнд тавих анхаарал халамжийг дээшлүүлэх
- ЕБС-дад хөнгөн хэлбрийн оюуны бэрхшээлтэй болон бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ерөнхий боловсролын сургуульд сурах стандарт журам боловсруулах, эдгээр хүүхдүүдийг сурлагын ахицаар үнэлэх
- ХБХ-дэд зориулсан арга зүйн болөөд техникийн шаардлага хангасан сурах бичигтэй болох
- Тусгай болон ерөнхий боловсролын сургуулиудад ажиллах мэргэжлийн багш сурган хүмүүжүүлэгчдээр хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоог хангах зорилгоор нийгмийн дэд бүтэц тухайлбал, налуу шат, нийтийн бие засах газарт тэдэнд зориулсан тусгай суултуур, зам талбайн тусгай тэмдэглэлийн стандарт боловсруулж улсын хэмжээнд мөрдүүлэх

- Сурч боловсрох эрх нь ноцтойгоор зөрчигдөж буй хүнд хэлбрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тодруулбал саажилттай болон тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах зорилгоор ЕБС-дад болон цэцэрлэгүүдэд тусгай анги нээн ажиллуулах

Хоёр. Эрүүл байх, эмнэлгийн тусламж үйлчилгээ хүртэх эрх

Судалгааны энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй нийт 102 хүүхдүүд, эрүүл мэндийн байгууллагын 14 ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нийт 23 эцэг эхчүүд, мөн тусгай сургалттай сургуулийн 18 багш сурган хүмүүжүүлэгчид оролцлоо.

Судалгаанд оролцсон хүүхдүүдээс эрүүл байх, эмнэлгийн тусламж үйлчилгээ хүртэх эрхтэй холбоотой тусгайлан бэлтгэсэн асуумжаар, бусад оролцогчдоос бүлгийн болон хувьчилсан ярилцлагаар судалгааны энэ хэсгийг зохион байгуулан явууллаа.

Монгол Улсын “Эрүүл мэндийн тухай” хууль, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 24-р зүйлд заасан “эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах урьдчилсан үндсэн нөхцөл болох эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байх

ёстой⁴-г үндэслэн судалгаанд оролцсон хүүхдүүдээс бид дараах асуултыг асуумжаар авлаа.

Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй эсэх.




Нийт хүүхдүүдийн 92% нь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй гэж хариулсан бол 8% нь үгүй гэсэн хариулт өгсөн байна. Эдгээр эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй гэж хариулсан хүүхдүүдийн үнэмлэхүй олонхи нь буюу 95,8% нь ямар нэгэн байдлаар шилжилт хөдөлгөөн хийсэн айлын хүүхдүүд байна. Энэ нь хөдөө орон нутгаас шилжиж ирсэн хүүхдүүд албан ёсны бүртгэл хамрагдаж чадахгүй цаашлаад эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ авч чадахгүйд хүрч байгааг харуулж байна. Энэ бодит байдлыг 2005 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хорооны 39-р чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 43-т мөн дурдаж байжээ.

⁴НҮБ-ын ХЭК 24-р зүйл


Эмнэлэгт үзүүлэхэд бэрхшээл байгаа эсэхээ хүүхдүүд дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 9. Эмнэлэгт үзүүлэхэд бэрхшээлтэй эсэх.



Асуултад хариулсан нийт хүүхдүүдийн 54% нь эмнэлэгт үзүүлэхэд бэрхшээлгүй гэж хариулсан бол, 46% нь эмнэлэгт үзүүлэхэд ямар нэгэн бэрхшээлтэй байдаг тухайгаа дурджээ. Ямар бэрхшээл байдаг тухайгаа хүүхдүүд дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 10. Эмнэлэгт үзүүлэхэд зонхилон тохиолддог хүндрэлүүд.



Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 26% нь эмнэлэгт үзүүлэхэд төлбөртэй үүнээс шалтгаалж санхүүгийн хүндрэл учирдаг тухайгаа хариулжээ. 21% нь эмч, эмнэлгийн ажилтны харьцаа муу байдгийг, мөн 19% нь харьяалагдах эмнэлэг нь тухайн хүүхдийн гэрээс хол байдаг тухай дурдсан байна.

17% нь хэрэв тухайн хүүхэд бие нь өвдсөн тохиолдолд хаана үзүүлэхээ мэддэггүй гэсэн бол үлдэж буй 17% нь эмнэлэгт хамт явж үзүүлэх хүнгүй тухайгаа хариулжээ.

Хувьчилсан болон бүлгийн

ярилцлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Эрүүл байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах” эрхийн байдлыг тодруулах судалгааны энэ хэсэгт эрүүл мэндийн байгууллагын эмч, сувилагч 17, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх 23 мөн 8 багш сурган хүмүүжүүлэгчид оролцон бидний асуултанд хариулт өгсөн юм. Энэ удаагийн хувьчилсан болон бүлгийн ярилцлагаар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23, 24, 25-р зүйлүүдэд заасан хүүхдийн эрүүл байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийн заалтууд дээр үндэслэн судалгаанд оролцогчидтой урьдчилан боловсруулсан асуултын дагуу хувьчилсан болон бүлгийн ярилцлагыг зохион байгуулав.

Ярилцлагаар, дараах асуудлуудыг хөндөн ярилцав. Үүнд:

- Орон нутагт зонхилон тохиолдож буй хөгжлийн бэрхшээлийн хэлбрүүд;
- Эрүүл мэндийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн

эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд шаардлагатай эм тариа, тэдгээрийн эмчилгээ, оношлогоонд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ;
- Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч нарын тусламж, үйлчилгээ;

Судалгаанд оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “эрүүл байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах” эрхийн өнөөгийн байдлыг дараах байдлаар тодорхойллоо. Орон нутагт цаашлаад улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тодорхой нэгдсэн бодлого байдаггүй талаар судалгаанд оролцогчид тэмдэглэлээ. Хүнд хэлбрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тодруулбал, саажилттай болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүд зөвхөн эцэг эхийн халамжинд байхаас эрүүл мэндийн байгууллагын зүгээс ямар нэгэн хяналт, тусгайлсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэггүй харин ч тээршаах байдал түгээмэл байдаг тухай дурджээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23-р зүйлийн 2-т зааснаар хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэд онцгой халамж хүртэх эрхийг хүлээн зөвшөөрөх⁵ тухай заасан байдгаас гадна 24-р зүйлийн 1, тус зүйлийн 2-ийн б-д мөн л хүүхдийн эрүүл мэндийг нөхөн сэргээх, өвчнийг эмчлэх, эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламжийг үзүүлэх⁶ тухай заажээ. Гэтэл өнөөгийн манай нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн эрхийн байдал нилээд өөр байдалтай байгааг судалгаанд оролцогчид онцолж байна. Тухайлбал, эмнэлгийн удирдлага, эмнэлгийн эмч ажилтан нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн талаар цэгцтэй ойлголт байхгүй эдгээр хүүхдүүдийн эрүүл мэндийн талаар тусгайлан хийгдэж буй ажил байхгүй байгаа нь судалгааны явцад харагдаж байлаа. Мөн ярилцлагын үед судалгаанд оролцогчдын тодруулан ярилцахыг хүссэн нэг зүйл нь эрүүл мэндийн салбарын анхан ба дунд шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, эдгээрт ажиллагсадын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах хандлагын талаар байлаа. Өрхийн эмч нарын зан харьцаа тааруу, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндэд анхаарах анхаарал халамж сул талаар судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд сэтгэл

зовнин ярьсан байна. Түүнчлэн эмч нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, сувилгаа, эмчилгээ оношлогооны талаархи мэдлэг тааруу байдгыг дурджээ. Ярилцлагаар өөр нэг анхаарал хандуулан ярилцсан асуудал нь хөгжлийн бэрхшээлийн хэлбрүүд тэдгээрийн шалтгааны талаар байлаа. Ярилцлагад оролцсон эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтэн нарын тодорхойлсноор, хараа сонсгол хэл ярианы бэрхшээлүүд зонхилдог байна. Тухайлбал, Дорнод аймгийн хэмжээнд нийт хөгжлийн бэрхшээлүүдийн 40 гаруй хувийг хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлүүд эзэлдэг байна.

Дээрх хөгжлийн бэрхшээлүүдийн үндсэн гол шалтгаан нь эрт оношилж эмчилгээ хийгдэхгүй байгаагаас шалтгаалж буйг дурджээ. Хөдөө орон нутагт тулгуур эрхтний олдмол хөгжлийн бэрхшээл элбэг байдаг ба энэ нь хөдөөгийн малчдын хүүхдүүдийн дунд ихэнхдээ тохиолддог учир нь малчин айл өрхийн эрхэлж буй аж ахуй, амьдралын хэв маягтай холбоотойгоор морь малнаас унаж гэмтэх үед үүссэн хөгжлийн олдмол бэрхшээлүүд байдгийг тэмдэглэжээ. Сүүлийн үед өвөл зуны аль ч улиралд морины уралдаан зохион байгуулдаг болсонтой холбоотой үүнээс шалтгаалан үүсэх олдмол хөгжлийн бэрхшээл түгээмэл болох

⁵⁶ НҮБ-ын ХЭК

хандлагатай байгааг эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтэн нар ярилцлагын үед дурджээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 24 дүгээрт зааснаар тухайн улс эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эцэг эхчүүдэд зориулсан удирдамж заавар, гэр бүл төлөвлөлтийн боловсрол, үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай арга хэмжээ авах тухай заажээ. Гэтэл манай улсын хувьд ялангуяа хөдөө орон нутагт бодит байдал өөр байна. Сум, багын төвшинд нөхөн үржихүйн талаархи сургалт, сурталчилгаа хангалтгүй үүнээс шалтгаалж хөдөө орон нутагт амьдарч байгаа хүмүүст гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн мэдлэг боловсрол байхгүй ба цус ойртолт, архи дарснаас үүдэлтэй оюуны хомсдолтой хүүхэд төрөх явдал элбэг болсон байна. Түүнчлэн төрөлтийг зөв удирдаж чадаагүй эрүүл мэндийн салбарийн эмч эмнэлгийн ажилтан нарын мэдлэг чадвар сул тэдгээрийн хайхрамжгүй үйл ажиллагаанаас шалтгаалж төрөх замд хүүхдийн нугас мэдрэл гэмтэн саажилттай хүүхэд мэндлэх явдал байсаар байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн байна. Үүнээс гадна эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зохих ёсоор

үзүүлж чадахгүй байгаагийн нэг гол шалтгаан нь ялангуяа хөдөө орон нутагт эрүүл мэндийн боловсон хүчин дутагдалтай байгаатай холбоотой байна. Энэ талаар 2005 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооны 39-р чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн зөвлөмжийн 44-рт заахдаа “...бүх бүс нутгийн хүүхдүүд тэр дундаа алслагдсан хөдөө орон нутагт байгаа хүүхдүүдэд эрүүл мэндийн чанартай үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүртээхийн тулд тус салбарт санхүүгийн болон хүний нөөцийг зөв хувиарлахыг⁷...” чухалчилан зөвлөсөн байна.

Дээрх дурдсан байдлуудаас үзэхэд төр засгаас эдгээр сөргөөр нөлөөлж буй шалтгаануудыг арилгах талаар үйл ажиллагааг авч хэрэгжүүлбэл улсын хэмжээнд төрөлхийн болон олдмол шалтгаанаар үүсэж буй хөгжлийн бэрхшээлийг бодитойгоор бууруулж болох юм.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23-р зүйлийн 2-т “... хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд онцгой халамж хүртэх эрхийг хүлээн зөвшөөрч, хүүхэд болон түүний эцэг эх, асран халамжлах бусад хүний нөхцөл байдлыг харгалзан, тэдний гаргасан хүсэлтийн дагуу нөөц боломжийнхоо хирээр тусалцаа үзүүлэх, онцгой халамж

⁷ НҮБ-ын ХЭХ-ны зөвлөмж

27

анхаарал тавихыг дэмжинэ”⁸ гэж заажээ. Түүнчлэн, тус зүйлийн 3-рт “... хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцгой хэрэгцээг ухамсарлан, эцэг эх буюу хүүхдийг асран халамжлах бусад хүмүүсийн нөөц бололцоог харгалзан тусламжийг аль болох үнэ төлбөргүй үзүүлэх”⁹...”ийг тус тус заажээ. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн 2-ийн 6-д “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эм, эмчилгээгээ тогтмол авч өөрсдийн үйл ажиллагааны төвшинг сайжруулах эсвэл хэмжээнд нь байлгах хэрэгцээг Улс орнууд баталгаажуулах ёстой”¹⁰-г заажээ. НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенци мөн уг Стандарт Дүрмийн эдгээр заалтыг үндэслэн судалгаанд оролцогчидтой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нэн шаардлагатай эм тариа, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамжийн талаар ярилцав. Аймаг, сум, багт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эм тарианы хүрэлцээ хангамж гэж ерөнхийдөө байхгүй гэдгийг судалгаанд оролцогчид тэмдэглэж байна. Бүсийн оношлогоо эмчилгээний төвд ч эдгээр хүүхдүүд эрүүл мэндийн оношлогоо эмчилгээ

хийгдэхгүй заавал Улаанбаатарт очиж эрүүл мэндийн байгууллагад хандах шаардлагатай болдог байна. Энэ нь зардал ихтэй байдаг учраас орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмчилгээ оношлогооны асуудал ихэвчлэн орхигдож үлддэг тухайгаа дурджээ. Мөн нийслэл болоод аймаг орон нутагт ч нөхөн сэргээх төвүүд хүрэлцээтэй бус байна. Үйл ажиллагаа явуулж буй нөхөн сэргээх төвүүд нь төр засгийн зүгээс бус ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг тусалцаатайгаар үйл ажиллагаагаа явуулж буйг судалгаанд оролцогчид дурдсан байна. Ийнхүү хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрүүл мэндийн эрхийн байдлын талаархи судалгаанд оролцсон хүүхдүүдээс авсан асуумж судалгаа болон бусад оролцогчидтой хийсэн бүлгийн болоод хувьчилсан ярилцлагаас дүгнэлт хийн дараах судалгааны санал зөвлөмжийг гаргаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрүүл байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртэх эрхтэй холбоотой санал зөвлөмж

Судалгааны энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй нийт 102 хүүхдүүд, эрүүл мэндийн байгууллагын 14 ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нийт 23

^{8,9} НҮБ-ын ХЭК

¹⁰ НҮБ-ын стандарт дүрэм

эцэг эхчүүд, мөн тусгай сургалттай сургуулийн 18 багш сурган хүмүүжүүлэгчид оролцлоо.

Судалгаанд оролцогчдоос авсан асуумж, хувьчилсан болон бүлгийн ярилцлагыг үндэслэн дараахь санал зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төр засгаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар баримтлах нэгдсэн эрүүл мэндийн бодлоготой болох
- Олон нийтийн ялангуяа эрүүл мэндийн салбарт ажиллагсадын хандлагыг өөрчлөх
- Орон нутагт ажиллаж буй эмч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, бүсийн оношлогооны төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд оношлогоо, эмчилгээг хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлж өношлох, эмчлэх
- Орон нутагт ажиллах эрүүл мэндийн боловсон хүчний хангамжийг сайжруулах, тэдгээрт орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангаж өгөх
- Орон нутагт амьдарч буй хүмүүсийн гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн мэдлэгийг дээшлүүлэх энэ талаар мэргэжлийн сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах


- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зайлшгүй шаардлагатай эм тарианы хангамжийг сайжруулах
- Нийгэм, эдийн засгийн үндэслэлийг тооцон бүх аймагт нөхөн сэргээх төвүүдийг нээн ажиллуулах

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдийн нийгмийн халамж үйлчилгээ Судалгааны энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй нийт 102 хүүхдүүд, нийгмийн халамжийн байгууллагын 8 ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан 4, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нийт 23 эцэг эхчүүд, мөн тусгай сургалттай сургуулийн 18 багш сурган хүмүүжүүлэгчид оролцлоо.


Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдээс асуумж судалгаагаар, бусад оролцогчдоос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм хамгааллын асуудлаар бэлтгэсэн асуултаар судалгааны энэ хэсгийг зохион байгуулж явуулав. Судалгаанд оролцсон хүүхдүүд нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагддаг эсэхээ дараах байдлаар хариуллаа.

Хүснэгт 11. Нийгмийн халамж үйлчилгээ авдаг эсэх



Асуултанд хариулсан нийт хүүхдүүдийн 55% нь нийгмийн халамжийн сангаас ямар нэг тусламж авдаг, 45% нь нийгмийн халамжийн сангаас ямарч тэтгэмж авдаггүй гэж хариулсан байна. Судалгаанд оролцсон хүүхдүүд ямар төрлийн нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт эдэлдэг тухайгаа дараах байдлаар хариулсан байна.


Хүснэгт 12. Ямар төрлийн нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт авдаг вэ?



Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 58% нь групнын тэтгэвэр авдаг, 27% нь байнгын асаргааны тэтгэмж, үлдэж буй 15% нь бусад төрлийн тэтгэмж авдаг гэж тус тус хариулсан байна. Уг судалгаанд оролцсон хүүхдүүдээс тухайн хүүхдэд төр засаг, олон нийт, гэр бүл, найз нөхдийн аль нь илүү тусалдаг тухай асуухад хүүхдүүд дараах байдлаар хариулсан байна. Судалгаанд хамрагдсан

хүүхдүүдийн хариултыг дараах хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 13. Танд хэн илүү тусалдаг вэ?



Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 87% нь тэдний гэр бүлийнхэн нь ойлгож тэдэнд тусалж дэмждэг гэж хариулсан бол 13% нь тэдний найз нөхөд нь тэдэнд илүү тусламж дэмжлэг үзүүлдэг гэж хариулсан байна.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн эцэг эх, тэдний асран хамгаалдаг хүн нь ажил хөдөлмөр эрхэлдэг эсэх талаар хүүхдүүд дараах байдлаар хариулсан байна.

Хүснэгт 14. Таны асран хамгаалагч ажил эрхэлдэг эсэх.



Хариулт өгсөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 52% нь тэдний эцэг эх, асран хамгаалагч хүн нь ямар нэг ажил хөдөлмөр эрхэлдэг гэж хариулсан бол 48% нь тэдний эцэг эх, асран хамгаалагч

хүн нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй гэж хариулсан байна.

Бүлгийн болон хувьчилсан

ярилцлага

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенци, Монгол Улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгмийн Хамгааллын Тухай Хуулийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн халамж үйлчилгээ хүртэх эрхийн байдлыг тодруулах зорилгоор уг ярилцлагыг зохион байгуулав.

Ярилцлагад нийгмийн хамгааллын салбарын 8 ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан 4, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нийт 23 эцэг эхчүүд, мөн тусгай сургалттай сургуулийн 18 багш сурган хүмүүжүүлэгчид оролцлоо.

Ярилцлагаар дараах асуудлуудыг хөндөн ярилцав. Үүнд:

- Нийгмийн халамжийн байгууллагаас ХБХ-д үзүүлж буй тусламж, үйлчилгээ төрөлжсөн асрамжийн үйлчилгээ бий эсэх;

- Нийгэм, хамт олны амьдралд оролцох, мэргэжлийн баримжаа олгох талаар баримталж буй бодлого, энэ чиглэлээр хийгдэж буй ажлууд;

- Нийгмийн амьдралд ХБХ идэвхтэй оролцоход дэмжлэг болох зорилгоор хийгдэж буй ажлууд тухайлбал, нийтийн үзвэр үйлчилгээний газрын гарц, орц, замын тэмдэглэл, гарцыг эдгээр иргэд болон хүүхдүүдэд зориулан зассан эсэх;

- ХБХ-ийн эцэг эхийн нийгмийн байдал тухайлбал, боловсрол, цалин, өрхийн орон сууцны байдал;

Судалгаанд оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн “нийгмийн хамгаалал, нийгмийн халамж үйлчилгээ хүртэх” эрхийн өнөөгийн байдлыг дараах байдлаар тодорхойллоо. Монгол Улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгэм Хамгааллын Тухай Хуулийн 4.1-т “хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд нийгмийн хамгааллын тодорхой үйлчилгээнд хамрагдах эрхтэйг”¹¹ заасан

боловч энэ хуулийн зарим заалтууд хэрэгжихгүй байгааг судалгаанд оролцогчид дурджээ. Тухайлбал, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж, тэтгэвэр, тэтгэмж авах хуульд заасан эрхүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд зөрчигдсөөр байгааг судалгаанд оролцогчид онцолж дурджээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зарим эцэг эхчүүд, асран хамгаалагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн хамгааллын талаарх хууль эрх зүйн актын

мэдлэг сул байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Энэ нь хууль батлагдан гардаг боловч түүний хэрэгжилт муу, батлагдсан хууль, эрх зүйн актыг олон нийтэд сурталчилж, таниулдаггүйтэй холбоотой байгаагийн тод жишээ юм.

Төрийн үйлчилгээний байгууллагад ажиллагсадын хууль, эрх зүйн актын талаар мэдлэг сул энэ байдлаас болж эцэстээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хохирч байгааг дараах кейс жишээнээс харна уу.

Миний хүү Дашням цус харвалтын улмаас биеийн баруун тал саажилттай болж удаан хугацаагаар хэвтэж эмчлүүлж дараа нь нөхөн сэргээх эмчилгээнд (иллэг, массаж, усан эмчилгээ, сургалт) тогтмол явж нөхөн сэргээх төвөөр эмчлүүлж үр дүнд хүрч сайжирч байна. Тогтмол таталтын эсрэг эм хэрэглэдэг. Франц улсад үйлдвэрлэсэн “депакин” гэдэг эмийг мэдрэлийн их эмчийн хяналтаар хэрэглэж байна. Уг эм 1 хайрцаг нь 26 000 төг бөгөөд сард 2 хайрцагийг уух шаардлагатай байдаг. Сард 52 000 төг болдог. Одоо 10 жил хэрэглэж байгаа ба цаашид ч тогтмол уух шаардлагатай гэж үздэг. Би өрхийн эмчийн тодорхойлолтоор аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмч нарын зөвлөгөөнөөр тэтгэлэгт хамруулж өгөхийг хүсч байсан боловч ээж нь ажил хийдэг орлоготой учир тэтгэлэг олгохгүй гэж өвчний картанд тэмдэглэсэн. Гэтэл УБ хотын мэдрэлийн их эмч хуулийн заалт байдаг тэтгэлэгт хамруул эмийг хөнгөлттэй үнээр авч уулга гэсэн тодорхойлолт өгсөн.

¹¹ МУ-ын ХБИ-ий НХ-ийн тухай хууль

¹² НҮБ-ын стандарт дүрэм

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48-р чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн 15.3-г “...хөгжлийн бэрхшээлийн талаар тусгай хууль, тогтоомж гаргах, хууль тогтоомжид зорим нэг онцгой сэдвүүдээр хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хамруулах, мөрдөж буй хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэхийг онцгойлон дурдсан заалт оруулах”¹² тухай дэлгэрэнгүй заажээ. Гэтэл судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд нөгөө талаас нийгмийн халамжийн байгууллагын мэргэлжилтэн нарын тайлбарласнаар хууль тогтоомжийн зарим заалтууд хэтэрхий бүрхэг тодорхойгүй байдгаас шалтгаалж нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдахад бэрхшээл учирдагыг тэмдэглэж байлаа. Тусгай сургалттай сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ахуйн хэв шинжинд сургах, нийгэм, хамт олны амьдралд оролцох, мэргэжлийн баримжаа олгох талаар үндсэндээ анхаарч үйл ажиллагаагаа явуулдаг талаар тусгай сургуулийн багш сурган хүмүүжүүлэгчид ярьсан байна. Гэвч энэ нь боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд эдгээр үйл ажиллагаа

явагдаж байгаа ба харин боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд тэднийг нийгмийн амьдралд оролцуулах, мэргэжлийн чиг баримжаа олгох тал дээр ямарч санал санаачилга байхгүйг дурджээ.

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн Нийгмийн Хамгааллын Тухай Хуулийн 9.3.4-т “гэрлэн дохио, нийтийн үзвэр, үйлчилгээний газрын талбай, зам, харьцаа, холбооны хэрэгсэл эдгээр иргэдийн хэрэгцээ, шаардлагад зохицсон байх”¹³ тухай хуульчлан заасан байна.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48-р чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн 5.1-т “... гэр орон, байшин барилга, нийтийн тээврийн үйлчилгээ болон бусад тээврийн хэрэгслүүд, гудамж, талбай, зам мөн бусад гадаад орчин зэргийг хүртээмжтэй байлгахад анхаарлаа хандуулах ёстой”¹⁴-г заажээ. Уг дүрмийн 5.3-т “барилга байгууламжийн бүтэц дизайнд үйл явцын эхнээс саадгүй орчин бий болгох хүртээмжийн шаардлагыг хамруулах ёстой”¹⁵-г мөн заасан байна. Нийгмийн амьдралд ХБХ идэвхтэй оролцоход дэмжлэг болох зорилгоор хийгдэж буй ажлууд тухайлбал, нийтийн үзвэр үйлчилгээний газрын гарц, орц, замын

тэмдэглэл, гарцыг эдгээр иргэд болон хүүхдүүдэд зориулан засах үйл ажиллагаа явагдахгүй байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн байна. Ярилцлагын явцад дараагийн хөндөн ярилцсан асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн нийгмийн байдал тухайлбал, боловсрол, цалин орлогын талаар юм.

Ихэнх тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд амьжиргааны дундаж болон түүнээс доогуур төвшинд амьдарч байна. Энэ нь нийгэм, эдийн засгийн олон талт шалтгаантай юм. Ялангуяа нийгэм, эдийн засгийн хямралаас шалтгаалсан ядуурал, ажилгүйдэлтэй холбоотой байна. Үүнээс гадна, хүнд хэлбрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тухайлбал саажилттай болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн амьдрал эдийн засгийн хувьд ихээхэн хүндрэлтэй байдаг нь судалгааны явцад тод харагдаж байлаа. Учир нь хүнд хэлбрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн гишүүний нэг нь хүүхдээ асарсны улмаас ажил эрхлэх боломжгүй байдаг. Иймээс эрүүл хүүхэдтэй гэр бүлийн өрхийн орлоготой харьцуулахад ХБХ-тэй гэр бүлийн орлого дунджаар 50%-аар бага байдаг. ХБХ-ийн нийгмийн халамж үйлчилгээний талаар явуулсан асуумж судалгаа, хувьчилсан

¹³ МУ-ын ХБИ-ийн НХ-ийн тухай хууль

^{14, 15} НҮБ-ын стандарт дүрэм

болон бүлгийн ярилцлагаас гарсан дүгнэлтийг үндэслээд судалгааны зөвлөмж гаргав.

**ХБХ-ийн нийгмийн халамж
үйлчилгээний эрхтэй холбоотой
судалгааны санал зөвлөмж**

- *Нийгмийн халамжийн тухай хуулийг ХБХ-тэй эцэг эх, олон нийтэд сурталчилах,*
- *Хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх заалтыг тодруулж оруулах, Тухайлбал: шалгуур үзүүлэлт, тэтгэвэр тэтгэмж*
- *Хуулинд заасан шалгуур үзүүлэлтийн зарим заалтыг уян хатан болгох,*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх талаар тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, Тухайлбал: бага хүүтэй зээл олгох, аж ахуй эрхлэх тал дээр төр засгаас дэмжих,*
- *Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг бий болгох,*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцоог дээшлүүлэхэд зайлшгүй нэн шаардлагатай тэдэнд зориулсан нийгмийн тусгай дэд бүтцийг бий болгох,*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд мэргэжлийн баримжаа олгоход төр засгаас анхаарах,*


Дөрөв. Нийгмийн оролцоо

Судалгааны энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн “нийгмийн оролцоо” тодорхойлох зорилгоор тусгайлан бэлтгэсэн асуумжаар судалгааны саналыг авлаа.

Монгол Улсын Үндсэн Хууль, бусад хууль тогтоомжууд түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн заалтуудыг үндэслэн уг судалгааг явуулав.

Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй нийт 102 хүүхдүүд тэдний нийгмийн оролцоо, хуульд заасан тэдний эрхийн мэдлэгийн талаар дараах байдлаар хариулт өгсөн байна.

Хүснэгт 15. Нийгэм, соёлын арга хэмжээнд оролцдог эсэх



Судалгаанд оролцсон нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 60% нь үзвэр үйлчилгээнд огт хамрагдаггүй (үздэггүй), үлдэж буй 40% нь үйлчилгээнд хамрагддаг (үздэг) гэж хариулсан байна. Үзвэр, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа үндсэн шалтгаанаа хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдүүд дараах байдлаар тайлбарлажээ.


Хүснэгт 16. Үзвэр үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагийн шалтгаан



Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 15% нь үзвэр, үйлчилгээний газар гэрээс нь хол байдаг тухайгаа, 26% нь тухайн хүүхэд нь өөрийн хөгжлийн бэрхшээлээсээ шалтгаалж үзвэр, үйлчилгээ үзэж чаддаггүйгээ, 10% нь унааны хүндрэлтэй байдлаас болж үзвэр, үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй тухайгаа илэрхийлсэн байна. Мөн 8% нь хаана очихоо мэддэггүй, 39% нь үйлчилгээний газар орж, гарахад хүндрэлтэй байдаг гэж хариулжээ. 2% нь хариулт өгөөгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор уг хүүхдийг хэн нэгэн гомдоосон эсэх тухай хүүхдүүд дараах хариултыг өгсөн.

Хүснэгт 17. Хөгжлийн бэрхшээлтэй чинь холбоотойгоор хэн нэгэн таныг гомдоосон эсэх



Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 63% нь хэн нэгэн тухайн хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор гомдоож байгаагүй, 37% нь тухайн хүүхдийг хэн нэгэн хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор гомдоож байсан тухай хариулжээ.

Нийгэм, олон нийтийн болон гэр бүл доторх харьцааг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 18. ХБХ-дэд дараах зүйл тохиолддог эсэх



Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 35% нь хүмүүс гайхан хардаг (сургуулийн бус орчинд), 27% нь өөрийн хөгжлийн бэрхшээлээс шалтгаалж бусдаас ичдэг, 10% нь гэрийнхэн нь зодож дарамталдаг, 27% нь тухайн хүүхдийг гэр орноос нь гаргадаггүй гэж тус тус хариулжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийнхэн нь ойлгодог эсэх талаар хүүхдүүд дараах байдлаар хариулсан байна.


Хүснэгт 19. ХБХ-ийг гэрийнхэн нь ойлгодог эсэх



Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 73% нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийнхэн нь ойлгодог гэж хариулсан бол 27% нь гэр бүлийнхэн нь тухайн хүүхдийг сэтгэл санааны хувьд нь ойлгогдоггүй гэж хариулжээ.

Тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сэтгэл санааны хувьд ганцаардмал байдлаа дараах байдлаар хариулсан байна.

Хүснэгт 20. Сэтгэл санааны хувьд ганцаарддаг эсэх




Нийт судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 44% нь сэтгэл санааны хувьд ганцаарддаггүй гэж

хариулсан бол 55% нь ганцаарддаг тухайгаа дурджээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөртөө хир зэрэг итгэлтэй байдаг тухайгаа дараах байдлаар илэрхийлсэн байна.


Хүснэгт 21. Хүүхэд өөртөө итгэлтэй эсэх



Нийт хүүхдүүдийн 72% нь өөртөө итгэлтэй байж чаддаг тухайгаа, 28% нь өөртөө итгэлтэй байж чаддаггүй гэж хариулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэр орондоо байхдаа сэтгэл хангалуун байж чаддаг эсэхээ дараах байдлаар илэрхийлсэн байна.

Хүснэгт 22. ХБХ гэртээ хангалуун байдаг эсэх



Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн

82% нь гэр орондоо байхдаа сэтгэл хангалуун байж чаддаг, 18% нь гэртээ

сэтгэл хангалуун байж чадддаггүй гэж хариулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцооны талаарх судалгааны дүгнэлт, санал зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцоог уг судалгаанаас дараах байдлаар дүгнэж байна.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23-р зүйлийн 3-г зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцгой хэрэгцээг ухамсарлан тусламж үзүүлэх ингэхдээ “... хүүхдийн хөгжил, түүний дотор хүүхдийн соёлын болон оюун ухааны хөгжлийг хангах, нийгмийн амьдралд оролцох бололцоог бүрдүүлэх сургалт, эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээ, хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх, амралт, чөлөөт цагын боломжоор хангахад чиглэсэн”¹⁶ байх тухай заажээ.

Түүнчлэн Монгол Улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгмийн Хамгааллын Тухай Хуулийн 2-р зүйлийн 4.1.9-г хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэд нь “... соёл, урлагын үйлчилгээнд хамрагдах”¹⁷ эрхтэйг заасан байна. Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48-р чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох”

¹⁶ НҮБ-ын ХЭК

¹⁷ МУ-ын ХБИ-ий НХ-ийн тухай хууль

¹⁸ НҮБ-ын стандарт дүрэм

Стандарт Дүрмийн 26-т “ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн нэг гишүүн бөгөөд орон нутгийн хамт олон дотроо эрхээ эдлэх ёстой. Тэд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн үйлчилгээний энгийн бүтцээс хэрэгцээт тусламж дэмжлэг авах ёстой”¹⁸-г заасан байна. Гэтэл судалгаанд оролцсон нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаас илүү хувь нь нийгмийн амьдралд оролцоход хүндрэлтэй байдаг тухайгаа дурдсан байна. Энэ нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд төдийгүй нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангахад зориулсан нийгмийн тусгай дэд бүтэц улсын хэмжээнд хөгжөөгүй байгаатай холбоотой байна.

Мөн судалгааны явцад олон нийтийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах хандлага тийм ч сайнгүй байгаа нь харагдлаа. Харин гэр бүлийн эдгээр хүүхдүүдэд хандах хандлага эерэг байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ялангуяа өсвөр насны эдгээр хүүхдүүд ганцаардмал байдаг нь судалгааны явцад тодорхой харагдаж байна. Тэд энэ наснаасаа эхлэн нийгэм хамт олноос хөндийрөх хандлагатай байдаг юм байна. Өсвөр насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцоог дэмжих

зайлшгүй шаардлагатай байдаг нь тодорхой байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцооны талаарх судалгааны дүгнэлтийг үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд;

- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай тэдэнд зориулсан нийгмийн дэд бүтэц тухайлбал нийтийн тээврийн хэрэгсэл, орон сууц, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц, тусгай тэмдэглэлүүдийг бий болгох, эдгээрийг стандартчилах*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хандах олон нийтийн хандлагыг өөрчилж эдгээр хүүхдүүдэд нийгэмд амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх*
- *Нийгмийн оролцоог дээшлүүлэх талаар боловсролын байгууллага санаачилга гарган ажиллах тодорүүлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш боломжийг хангах үүднээс тэдний аль болох хичээлийн бус цагаар олон нийтийн үйл ажиллагаа болон секц, дугуйланд хамруулах*

Тав. Эрхийн талаарх хүүхдүүдийн мэдлэг

МУ-ын үндсэн хууль, НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцийн эрхийн

талаарх мэдлэгийг тодруулах зорилгоор хүүхдүүдээс асуумж судалгаа авсан.

Хүснэгт 23. Амьд явах эрхийн мэдлэг




Судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 23% нь амьд явах эрхийг мэддэг, 6% нь мэдэхгүй гэсэн бол 71% нь сонссон гэж хариулжээ.

Хүснэгт 24. Хамгаалуулах эрхийн мэдлэг




Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 15% энэ эрхийг мэднэ гэж хариулсан бол 8% нь мэдэхгүй гэж хариулсан бол 77% нь энэ эрхийн талаар зөвхөн сонссон гэж хариулсан.

Хүснэгт 25. Эрүүл мэндийн үйлчилгээ авах




Нийт хүүхдүүдийн 15% нь эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг мэднэ гэж хариулсан бол 9% нь мэдэхгүй үлдэж буй 76% нь энэ эрхийн талаар зөвхөн сонссон гэсэн хариулт өгсөн.

Хүснэгт 26. Боловсрол эзэмших эрх




Энэ асуултанд нийт хүүхдийн 19% нь боловсрол эзэмших эрхийг мэднэ гэж хариулсан бол 5% нь мэдэхгүй, 76% нь зөвхөн сонссон гэж хариулсан.

Хүснэгт 27. Ялгаварлан гадуурхагдахгүй байх



Нийт хүүхдүүдийн 5% нь энэ эрхийн талаар мэднэ гэж хариулсан бол 35% нь мэдэхгүй, 60% нь зөвхөн сонссон гэж хариулжээ.

Хүснэгт 28. Хүчирхийллээс ангид байх



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 6% нь мэднэ гэж, 33% нь нь мэдэхгүй гэж хариулсан бол 61% нь энэ эрхийн талаар сонссон гэж хариулсан байна.

Хүснэгт 29. Нийгмийн амьдралд тэгш оролцох



Нийт хүүхдүүдийн 17% нь нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийн талаар мэднэ, 19% нь мэдэхгүй, 64% нь сонссон гэж хариулсан байна.

Эрхийн мэдлэгийн талаарх судалгааны дүгнэлт, санал зөвлөмж

Монгол Улсын Үндсэн Хууль, НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенци-д заасан хүний үндсэн эрхийн талаар мэдлэг, ойлголт ямар төвшинд байгааг судалгаанд оролцсон нийт хүүхдүүдээс асуумжаар судалж үзлээ.

Судалгаанаас үзэхэд, судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн хүний эрхийн талаарх мэдлэг хангалттай бус төвшинд байгаа нь харагдлаа.

Энэ нь зөвхөн хувь хүний эрхийн тухай бус нөгөө талаар нийгэмд хүлээх үүргийн талаарх асуудал хөндөгдөж байгаа юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрэмд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ижил тэгш эрх эдлэхийн сацуу, ижил тэгш үүрэг хүлээх ёстой. Эдгээр эрхийг эдэлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгмийн үзэл бодол дээшлэх ёстой. Тэгш боломжийн нэг хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хариуцлагаа бүрэн хүлээх нийгмийн гишүүн гэж тооцож тэдэнд туслах явдал юм”¹⁹ гэж заажээ. Үүнтэй холбоотойгоор хүний эрх үүргийн тогтолцоог хүүхдүүдэд бага наснаас нь таниулж ойлгуулснаар тэднийг ирээдүйд

нийгмийн идэвхтэй гишүүн болж амьдрахад энэ нь нэгэн чухал суурь болох юм.

Судалгааны дээрх дүгнэлтээс үндэслэн дараах санал, зөвлөмжийн боловсрууллаа.

- *Батлагдсан хууль, тогтоомжийг хөгжлийн бэрхшээлтэй нийт хүмүүсийн тусгай хэрэгцээг харгалзан эдгээр хүмүүст зориулсан хууль эрх зүйн актуудын тусгай мэдээллийн сантай болгох*
- *Ингэхдээ брайлээр, том үсгийн фондоор бичих болон бусад тохирох технологийг ашиглан мэдээллийг хүртээмжтэй болгох*
- *Нийгмийн харьцааны гол тулгуур болох эрх үүргийн тогтолцоог хүүхдүүдэд багаас нь таниулж, ойлгуулах*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁹ НҮБ-ын стандарт дүрэм

ХАВСРАЛТУУД

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖИЛТЭНТЭЙ
ХИЙХ ХУВЬЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ

- Танай сургуульд ХБХ –ийн тоо хэмжээ
- ХБХ-ийн сурлага, сурах идэвх
- ХБХ-ийн сэтгэл зүйн байдал
- ХБХ-д хандах анги хамт олны хандлага
- Орон нутаг дахь сургуульд хамрагдаагүй ХБХ- ийн тоо
- Сургуульд хамрагдаж чадахгүй байгаа ХБХ- ийн шалтгаан
- ХБХ-дэд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр буй эсэх
- Багш сурган хүмүүжүүлэгчид ХБХ-тэй ажиллах чадвар, тэдэнтэй ажиллах арга зүйн сургалтанд хамрагдсан эсэх
- ХБХ-д боловсрол олгох тусгай хэрэгцээг хангах зорилгоор орон нутгын боловсролын байгууллагад хийгдэж буй ажлууд тухайлбал, ХБХ-дэд зориулсан сургалтын техник, тоног төхөөрөмж, сургууль анги танхимд орох, гарахад зориулсан тусгай гарц, нийтийн бие засах газарт тэдэнд зориулсан тусгай орц гарц
- ХБХ-ийн сурч боловсрох эрхийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд цаашид анхаарах зүйлсийн талаарх таны хувийн санал зөвлөмж

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖИЛТЭНТЭЙ
ХИЙХ ХУВЬЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ

- Орон нутгийн хэмжээнд зонхилон тохиолдож буй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг нэрлэнэ үү, гол шалтгаан нь юу вэ?
- Эрүүл мэндийн байгууллагаас ХБХ-ийн эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ
- Бодлогын хэрэгжилтэнд тулгарч буй гол саад бэрхшээл
- ХБХ-д шаардлагатай эм тариа, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ, хангамж
- Орон нутагт ХБХ-д нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээ тухайлбал мэс засал, нөхөн сэргээх эмчилгээ, согог засал, гоо заслын эмчилгээ үйлчилгээ тэдгээрийн бодит боломж, хүрэлцээ
- ХБХ-тэй ажилладаг мэргэшсэн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн дунд мэргэжлийн боловсон хүчний хангамж, хэрэгцээ шаардлага
- Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас ХБХ-д чиглэсэн тодорхой ажлууд (тусгай сургалт, урьдчилан сэргийлэлт)
- ХБХ-ийн эрүүл мэндийг хамгаалах эрхийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд цаашид анхаарах зүйлсийн талаарх таны хувийн санал зөвлөмж

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖИЛТЭНТЭЙ ХИЙХ ХУВЬЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ

- Орон нутгийн нийгмийн халамжийн байгууллагад байгаа ХБХ-ийн албан ёсны тоо
- ХБХ-ийн нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдсан хувь хэмжээ (тэтгэлэг тэтгэмж, сувилалд сувилуулах, тусгай асрамж үйлчилгээнд хамрагдах)
- Нийгмийн халамжийн байгууллагаас ХБХ-д үзүүлж буй тусламж, үйлчилгээ түүнд тулгарч байгаа шийдвэрлэвэл зохилтой асуудлууд
- Орон нутагт ХБХ-д зориулсан ОУБ, болон бусад байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл тэдний дэмжлэг оролцоо
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ бий эсэх
- ХБХ-д хандах олон нийтийн чиг хандлага
- Нийгэм, хамт олны амьдралд оролцох, мэргэжлийн баримжаа олгох талаар баримталж буй бодлого, энэ чиглэлээр хийгдэж буй ажлууд
- Нийгмийн амьдралд ХБХ идэвхтэй оролцоход дэмжлэг болох зорилгоор хийгдэж буй ажлууд тухайлбал, нийтийн үзвэр үйлчилгээний газрын гарц, орц, замын тэмдэглэл, гарцыг эдгээр иргэд болон хүүхдүүдэд зориулан зассан эсэх
- ХБХ-ын эцэг эхийн нийгмийн байдал тухайлбал, боловсрол, цалин, өрхийн орон сууцны байдал
- ХБХ-ийн нийгэм хамгаалалын эрхийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд цаашид анхаарах зүйлсийн талаарх таны хувийн санал зөвлөмж

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХБХ-ТЭЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДТЭЙ ХИЙХ ХУВЬЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ

- Нийгмийн халамжийн байгууллагаас ХБХ-д үзүүлж буй тусламж, үйлчилгээ түүнд тулгарч байгаа шийдвэрлэвэл зохилтой асуудлууд
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ бий эсэх
- ХБХ-д хандах олон нийтийн чиг хандлага
- Нийгмийн амьдралд ХБХ идэвхтэй оролцоход дэмжлэг болох зорилгоор хийгдэж буй ажлууд тухайлбал, нийтийн үзвэр үйлчилгээний газрын гарц, орц, замын тэмдэглэл, гарцыг эдгээр иргэд болон хүүхдүүдэд зориулан зассан эсэх
- ХБХ-ын эцэг эхийн нийгмийн байдал тухайлбал, цалин, өрхийн орон сууцны байдал
- Эрүүл мэндийн байгууллагаас ХБХ-ийн эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ
- ХБХ-д шаардлагатай эм тариа, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ, хангамж
- Орон нутагт ХБХ-д нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээ тухайлбал мэс засал, нөхөн сэргээх эмчилгээ, согог засал, гоо заслын эмчилгээ үйлчилгээ тэдгээрийн бодит боломж, хүрэлцээ
- Сургуульд хамрагдаж чадахгүй байгаа ХБХ-ийн шалтгаан
- ХБХ-ийн нийгэм хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн эрхийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд цаашид анхаарах зүйлсийн талаарх таны хувийн санал зөвлөмж

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

- Д.Даваадамдин- Social Monitoring Хөгжлийн Судалгааны төв
Судалгааны багийн ахлагч, Нийгмийн ухааны магистр, Анагаах Ухааны бакалавр
- Ж. Болорцэцэг – ХБХЭЭХ-ны гүйцэтгэх захирал
Судалгааны зөвлөх, Нийгмийн Ухааны бакалавр, сэтгүүлч
- н.Сангидорж – Арьсны өвчин судлалын төвийн захирал
Анагаах Ухааны доктор, профессор
- С.Ганзориг - “Social Monitoring” Хөгжлийн Судалгааны Төв
Судлаач, Нийгмийн Ухааны бакалавр
- Ш.Батбаяр - “Social Monitoring” Хөгжлийн Судалгааны Төв
Судлаач, Физик математикч, бакалавр

UIH.MN
СУДАЛГААНЫ САН